



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbfi@frc.mn

Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	3
Зургийн жагсаалт.....	3
Товчилсон нэрсийн жагсаалт	4
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	5
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт	7
Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	7
Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт	7
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт.....	7
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт	8
Статистик үзүүлэлтүүд	9
Харилцагчид, зээлдэгчид.....	9
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид	9
Тархалт	10
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	11
Мөнгөн хөрөнгө.....	12
Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	12
Факторингийн тооцооны авлага.....	13
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө	13
Зээл.....	13
Цахим зээл	16
Ногоон зээл	16
Бусад хөрөнгө	17
Эргэлтийн бус хөрөнгө	18
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт	19
Санхүүгийн эх үүсвэр	19
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	20
Бусад эх үүсвэр	20
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	21
Төслийн зээлийн санхүүжилт	22
Бусад өр төлбөр	22
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	22
Бусад өмч, сангууд	24
Хуримтлагдсан ашиг	24
Хоёрдогч өглөг.....	24
Ашигт ажиллагаа	25
Гадаад валютын арилжааны мэдээ	27
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	28
Дүгнэлт	29
Актив, пассивын бүтэц.....	29
Ашигт ажиллагаа	30
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	30

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл	5
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/	5
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа	6
Хүснэгт 5 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл	9
Хүснэгт 6 Статистик мэдээлэл /5 жилээр/	9
Хүснэгт 7 ББСБ-ын мэдээлэл	10
Хүснэгт 8 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа	10
Хүснэгт 9 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 10 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 11 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	11
Хүснэгт 12 Активын интервал /тэрбум төгрөгөөр/	11
Хүснэгт 13 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	12
Хүснэгт 14 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/	12
Хүснэгт 15 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/	13
Хүснэгт 16 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/	13
Хүснэгт 17 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	13
Хүснэгт 18 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/	15
Хүснэгт 19 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/	15
Хүснэгт 21 Зээлийн ангилал	16
Хүснэгт 23 Ногоон зээлийн тайлан /сая төгрөгөөр/	17
Хүснэгт 24 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/	17
Хүснэгт 25 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	18
Хүснэгт 26 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	19
Хүснэгт 27 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/	20
Хүснэгт 29 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/	20
Хүснэгт 30 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/	20
Хүснэгт 32 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/	21
Хүснэгт 33 Өрийн бичиг /валютаар/	21
Хүснэгт 36 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/	22
Хүснэгт 37 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/	22
Хүснэгт 38 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/	23
Хүснэгт 39 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/	23
Хүснэгт 45 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/	24
Хүснэгт 46 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/	24
Хүснэгт 48 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/	25
Хүснэгт 51 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/	26
Хүснэгт 52 2022 оны жилийн эцсийн байдлаарх валют арилжааны мэдээ /тэрбум төгрөгөөр/	27
Хүснэгт 53 Гадаад валютын арилжааны мэдээ /2022 он/	27
Хүснэгт 54 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/	28

Зургийн жагсаалт

Зураг 1 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	11
Зураг 2 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	12
Зураг 4 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/	14
Зураг 5 Зээлийн багцын чанар /хувиар/	14
Зураг 6 Олгосон зээл /хугацааны ангиллаар/	15
Зураг 7 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 8 ангиллаар/	17
Зураг 8 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	19
Зураг 9 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/	19

Зураг 10 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /мянган төгрөгөөр/	20
Зураг 11 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	21
Зураг 12 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	23
Зураг 13 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/	25

Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2022 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 513 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 21 ББСБ буюу 3.9 хувиар буурсан үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 93 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 26 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 5 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2018	2019	2020	2021	2022
Шинээр олгосон	15	14	14	14	17
Хүчингүй	10	15	20	12	38
Түдгэлзүүлсэн	22	13	34	29	65
Сэргээсэн	7	9	9	8	34
Нийт ББСБ	539	538	532	534	513
Үүнээс: ХОН	73	75	77	83	93
Үүнээс: ГХО	29	27	30	28	26
Салбар	230	250	295	331	427
Төлөөлөгч	5	7	9	8	8

2022 оны жилийн эцсийн байдлаар 17 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 38 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 65 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 34 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2022 оны жилийн эцсийн байдлаар 37 ББСБ үзүүлж байна.

Финтек зээлийн үйлчилгээний эрх зүйн орчин бүрдсэнтэй холбоотойгоор дээрх 37 ББСБ-ыг 2023 оны 6 сарын 30-ны өдрийн дотор журамд заасан шаардлагыг ханган бүртгүүлэх хугацаа өгсөн бол шинээр финтек зээлийн үйлчилгээ эрхлэх ББСБ-ууд нь журмын шаардлагыг ханган, бүртгүүлэх хүсэлтээ ирүүлэх боломжтой юм. Мөн журам батлагдсанаас хойш зөвшөөрөлгүй финтек зээлийн үйлчилгээ эрхэлж буй ББСБ-уудад журамд заасан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 30.1 хувиар өсөж, банкны

салбарын 7.7%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 78.8%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.1 пунктээр буурсан дүн юм. Энэ нь ББСБ-уудын бусдаас татан төвлөрүүлж буй эх үүсвэрийн хэмжээ нэмэгдэж байгааг харуулж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2021	2022	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	2,709.9	3,527.0	30.1%
Банкны салбартай харьцуулахад хувиар	6.6%	7.7%	1.1%
Нийт өөрийн хөрөнгө	1,799.1	2,191.6	21.8%
Банкны салбартай харьцуулахад хувиар	52.5%	49.2%	-3.3%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	1,114.1	1,275.7	14.5%
Банкны салбартай харьцуулахад хувиар	77.7%	78.8%	1.1%
Нийт зээл	2,012.2	2,722.6	35.3%
Банкны салбартай харьцуулахад хувиар	9.5%	12.1%	2.6%
Нийт орлого	521.3	867.9	66.5%
Нийт зарлага	311.3	554.9	78.3%
Цэвэр ашиг	210.0	312.9	49.0%

2022 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 30.1 хувиар буюу 817.0 тэрбум төгрөгөөр өсөж 3.5 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 87.0 хувийг цэвэр зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 52.0 хувийг өр төлбөрийн өсөлт, 48.0 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын нийт орлогын хэмжээ 66.5 хувиар буюу 346.6 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 78.3 хувиар буюу 243.7 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 49.0 хувиар буюу 102.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 513 ББСБ 10 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 93.0% нь буюу 477 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 59.8% нь буюу 307 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 140 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 27.3 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 36

ББСБ нийт ББСБ-уудын 7.0 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2021	2022	тоо	хувь
Нийт ББСБ-ын тоо					
1	Зээл	496	477	(19)	-3.8%
<i>Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>					
2	Факторинг	40	45	5	12.5%
3	Төлбөрийн баталгаа гаргах	24	28	4	16.7%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	5	-	-
5	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	36	37	1	2.8%
6	Гадаад валютын арилжаа	146	140	(6)	-4.1%
<i>Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>					
7	Итгэлцэл	49	64	15	30.6%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	20	22	2	10.0%
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	40	39	(1)	-2.5%
10	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	-	-

Зээл болон гадаад валют арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс харгалзан 3.8 хувь, 4.1 хувиар буурч, бусад төрлийн үйл ажиллагааны тоо нэмэгдэж байгаа нь ББСБ-ууд үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж байгааг харуулж байна. Харин өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл итгэлцлийн үйлчилгээ 30.6 хувиар, төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ 16.7 хувиар, факторинг 12.5 хувиар, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ 10.0 хувиар тус тус өссөн байна.

Тайлант улиралд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.11-д заасан үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг анх удаа [Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 223 дугаар тогтоолоор](#) олгосон байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль 2009 оны 7 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан бөгөөд үүнтэй холбоотой үйл ажиллагаа эрхлэх этгээдэд

Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл олгохоор Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж энэхүү тусгай зөвшөөрлийг нэмсэн бөгөөд 2022 оны эхний хагас жил хүртэл тусгай зөвшөөрөл авсан ББСБ байгаагүй юм.

2022 оны жилийн эцсийн тайлан мэдээний ирц 98.8% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 513 ББСБ-аас 507 ББСБ улирлын тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 5 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 1 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

Өмнөх улирлын байдлаар нэгтгэлд хамрагдсан 5 ББСБ-аас 2 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлэх арга хэмжээг Хяналт шалгалт зохицуулалтын газраас авч хэрэгжүүлсэн байна.

Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарт мөрдөгдөх дүрэм, журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээний хүрээнд дараах дүрэм журмуудыг шинэчлэн Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүллээ.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 160 дугаар тогтоолоор “[Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам](#)”-ыг баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2022 оны 4 дүгээр 28-ны өдрийн 5807 дугаарт бүртгэн авсан байна.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 287 дугаар тогтоолоор “[Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам](#)”-д нэмэлт өөрчлөлт оруулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдөр бүртгэн авсан байна.

- “[Банк бус санхүүгийн байгууллагаас олгох финтек зээлийн бүтээгдэхүүнд тооцох өр, орлогын харьцаа тогтоох тухай](#)” зохицуулалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 527 тогтоолоор баталсан бөгөөд өр, орлогын харьцааг 70 хувиас хэтрүүлэхгүй байхаар тогтоосон.

- Банк бус санхүүгийн байгууллага зээл олгохдоо зээлдэгчийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэмд үзүүлэх үр нөлөө, болзошгүй эрсдэлийг цогц, системтэй байдлаар тодорхойлох, үнэлэх, удирдах мөн байгаль орчны холбогдох стандарт, шаардлагыг зохих ёсоор хэрэгжүүлсэн эсэхийг тогтооход заавар болгон ашиглах зорилгоор “[Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах](#)

[үлгэрчилсэн заавар](#)”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 526 тогтоолоор баталсан.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2022 оны жилийн эцсийн байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 90.6 хувь буюу 454 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 84.4 хувь буюу 423 ББСБ хэрэгжүүлсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу ББСБ-ууд нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах, гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А-57 дугаар тушаалаар “Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журам”-ыг шинэчлэн баталсантай холбоотойгоор Монголбанкнаас мэдээлэл нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг нэгдсэн журмаар шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулж, тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 477 ББСБ-ын 89.3% буюу 426 ББСБ гэрээгээ шинэчлэн байгуулсан байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан

маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 133 ББСБ, 15,981 удаагийн тохиолдлоор, 1.1 их наяд төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 9 ББСБ, 33 удаагийн тохиолдлоор,

865.6 сая төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 501 ББСБ-аас 1,224.5 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөхөөс 98.5% буюу 497 ББСБ 1,206.1 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Статистик үзүүлэлтүүд

2022 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 26,993 хувьцаа эзэмшигчдийн 513 ББСБ, 427 салбар нэгж, 8 төлөөлөгчийн газар, 4,554 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 4.6 сая харилцагч, 1.2 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчид болон тоо өмнөх оны мөн үеэс 3.9 хувиар буурч давхардсан тоогоор 4,633,616-д, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 29.2 хувиар буурч 1,187,603-г хүрсэн байна.

Хүснэгт 4 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл

Статистик мэдээлэл	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	4,633,616	3,958,949	266,502	4,367,114	51,812	4,607,724	25,892	1,210,954	132,551
Үүнээс: Эмэгтэй	2,453,168	2,106,354	137,502	2,315,666	24,018	2,438,425	14,743	606,154	70,330
Эрэгтэй	2,174,280	1,851,723	123,589	2,050,691	23,659	2,163,183	11,097	604,317	61,937
Хуулийн этгээд	6,168	872	5,411	757	4,135	6,116	52	483	284
Итгэмжлэгчдийн тоо	7,365	7,363	3,073	4,292	-	7,359	6	2,080	297
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	1,537	1,481	101	1,436	-	1,525	12	1,133	354
Зээлдэгчдийн тоо	1,187,603	689,182	207,166	980,437	-	1,161,737	25,866	207,110	132,503
Хэвийн	1,013,576	582,605	179,820	833,756	-	992,683	20,893	171,418	107,804
Хугацаа хэтэрсэн	57,541	31,927	8,968	48,573	-	54,634	2,907	9,421	5,650
Чанаргүй:	116,486	74,650	18,378	98,108	-	114,420	2,066	26,271	19,049
-Хэвийн бус	35,875	22,151	4,746	31,129	-	35,415	460	7,667	4,853
-Эргэлзээтэй	44,928	29,586	4,488	40,440	-	44,266	662	9,818	7,768
-Муу	35,683	22,913	9,144	26,539	-	34,739	944	8,786	6,428
Зээлдэгчдийн насжилт	1,185,992	688,613	206,020	979,972	-	1,160,178	25,814	206,902	132,219
18-35 насны	695,935	394,828	89,848	606,087	-	683,436	12,499	124,174	79,918
36-45 насны	303,530	181,219	66,226	237,304	-	296,417	7,113	53,588	32,666
46-55 насны	142,911	85,975	36,810	106,101	-	138,510	4,401	24,126	15,731
55-аас дээш	43,616	26,591	13,136	30,480	-	41,815	1,801	5,014	3,904
Зээлдэгчдийн боловсрол	1,185,992	688,613	206,020	979,972	-	1,160,178	25,814	206,902	132,219
-Дээд	698,581	400,290	109,395	589,186	-	685,250	13,331	127,290	84,472
-Тусгай дунд	136,645	68,423	16,985	119,660	-	133,933	2,712	22,632	20,605
-Бүрэн дунд	262,891	160,118	60,754	202,137	-	254,659	8,232	46,152	21,186
-Дунд	74,346	48,463	9,346	65,000	-	73,092	1,254	8,959	5,514
-Бага	13,529	11,319	9,540	3,989	-	13,244	285	1,869	442

/Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно/

Нийт харилцагчдын 94.2% буюу 4,367,114 нь, зээлдэгчдийн 82.6% буюу 980,437 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж /финтек/, онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 5.8% буюу 266,502 нь, зээлдэгчдийн 17.4% буюу 207,166 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валютын арилжааны үйлчилгээ дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 51,812 буюу нийт харилцагчдын 1.1 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/

Үзүүлэлтүүд	2018	2019	2020	2021	2022	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	4,875	7,712	8,869	21,793	26,993	5,200	23.9%
Ажилчдын тоо	2,784	2,962	3,437	3,976	4,554	578	14.5%
Харилцагчдын тоо	1,601,749	2,854,530	2,844,782	4,820,624	4,633,616	(187,008)	-3.9%
Зээлдэгчдийн тоо	234,080	419,854	788,058	1,678,139	1,187,603	(490,536)	-29.2%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	3.3%	3.0%	2.8%	2.7%	3.1%	+0.4 пункт	

Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 23.9 хувиар буюу 5,200-гаар өсөж 26,993-д хүрчээ. Нийт хувьцаа эзэмшигчдийн 96.3 хувь буюу 25,997 нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 996 буюу 3.7% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 2,483 буюу 9.2% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа

эзэмшигчид байгаа бол 212 буюу 0.8% нь хөдөө орон нутгийн ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	26,993	26,159	1,833	25,160	54	26,781	212	25,997	2,483
Нийт ажилтнуудын тоо	4,554	2,286	2,572	1,982	87	4,293	261	392	430
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	2,727	1,322	1,561	1,166	51	2,546	181	256	246
Эрэгтэй ажилтны тоо	1,827	964	1,011	816	36	1,747	80	136	184

Хөдөө орон нутгийн 93 ББСБ 6 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ТЗ-тэй ББСБ-ын тоо	513	64	476	37	36	420	93	5	508	26
1 Зээл	477	64	440	37	-	385	92	5	472	26
2 Факторингийн үйлчилгээ	45	20	32	13	-	45	-	3	42	2
3 Төлбөрийн баталгаа гаргах	28	14	21	7	-	27	1	2	26	5
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	2	1	4	-	5	-	1	4	-
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	37	17	24	13	-	37	-	3	34	-
6 Гадаад валютын арилжаа	140	30	127	13	36	130	10	4	136	8
7 Итгэлцлийн үйлчилгээ	64	64	45	19	-	63	1	5	59	6
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	22	16	14	8	-	21	1	2	20	4
9 Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	39	23	28	11	-	37	2	4	35	5
10 Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	1	-	-	1	-	-	1	1

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 81.9% буюу 420 ББСБ, салбаруудын 63.5% буюу 271 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 18.1% буюу 93 ББСБ, салбаруудын 36.5% буюу 156 салбар бүсртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар 93 ББСБ-ын 427 салбар бүртгэлтэй байгаа ба эдгээрийн 62.3 хувийг 13 ББСБ-ын 266 салбар бүрдүүлж байна.

Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	420	271	691	100.0%
Сүхбаатар дүүрэг	143	41	184	26.6%
Чингэлтэй дүүрэг	114	39	153	22.1%
Баянгол дүүрэг	71	41	112	16.2%
Баянзүрх дүүрэг	47	65	112	16.2%
Хан-Уул дүүрэг	36	32	68	9.8%
Сонгинохайрхан дүүрэг	8	46	54	7.8%
Багануур дүүрэг	1	4	5	0.7%
Налайх дүүрэг		3	3	0.4%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон, Төв, Өвөрхангай аймгуудад, Улаанбаатар хотоос Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	93	156	249	100.0%
Төв аймаг	19	4	23	9.2%
Орхон аймаг	10	16	26	10.4%
Өвөрхангай аймаг	10	12	22	8.8%
Дархан-Уул аймаг	8	13	21	8.4%
Дорнод аймаг	5	13	18	7.2%
Сэлэнгэ аймаг	5	11	16	6.4%
Баянхонгор аймаг	5	7	12	4.8%
Сүхбаатар аймаг	5	6	11	4.4%
Увс аймаг	4	8	12	4.8%
Хэнтий аймаг	3	8	11	4.4%
Хөвсгөл аймаг	3	8	11	4.4%
Баян-Өлгий аймаг	3	4	7	2.8%
Өмнөговь аймаг	2	14	16	6.4%
Архангай аймаг	2	6	8	3.2%
Завхан аймаг	2	4	6	2.4%
Говьсүмбэр аймаг	2	3	5	2.0%
Булган аймаг	2	1	3	1.2%
Дорноговь аймаг	1	8	9	3.6%
Ховд аймаг	1	5	6	2.4%
Говь-Алтай аймаг	1	1	2	0.8%
Дундговь аймаг	-	4	4	1.6%

Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2022 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 3.5 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.1 хувиар буюу 817.0 тэрбум төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 87.0 хувийг зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2021 дүн	Нийт дүнд эзлэх хувь	2022 дүн	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
					дүн	хувь
Эргэлтийн хөрөнгө	2,616,456.3	96.5%	3,415,751.8	96.8%	799,295.4	30.5%
Мөнгөн хөрөнгө	429,712.7	15.9%	490,540.6	13.9%	60,827.9	14.2%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	22,588.6	0.8%	29,082.5	0.8%	6,493.8	28.7%
Зээл (цэврээр)	1,897,466.7	70.0%	2,571,251.2	72.9%	673,784.5	35.5%
Нийт зээл	2,012,173.7	74.3%	2,722,631.2	77.2%	710,457.5	35.3%
(Зээлийн эрсдэлийн сан)	114,707.0	4.2%	151,379.9	4.3%	36,673.0	32.0%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	9,869.0	0.4%	9,719.2	0.3%	-149.8	-1.5%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	13,617.0	0.5%	24,161.4	0.7%	10,544.4	77.4%
Бусад хөрөнгө	243,124.1	9.0%	290,968.7	8.2%	47,844.6	19.7%
Санхүүгийн үүсэмэл хэрэгсэл (дериватив)-ийн авлага	78.1	-	28.1	0.0%	-50.0	-
Эргэлтийн бус хөрөнгө	93,493.3	3.5%	111,207.5	3.2%	17,714.2	18.9%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө	119,460.9	4.4%	146,101.7	4.1%	26,640.8	22.3%
(Хуримтлагдсан элэгдэл)	-25,967.6	-1.0%	-34,894.2	-1.0%	-8,926.6	34.4%
Нийт хөрөнгийн дүн	2,709,949.6	100.0%	3,526,959.3	100.0%	817,009.7	30.1%

Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2017 оны мөн үед 969.2 тэрбум төгрөг байсан бол 2022 оны жилийн эцсийн байдлаар 3.6 дахин өсөж 3.5 их наяд төгрөгт хүрчээ. Энэ нь цэвэр зээлийн үлдэгдэл 4.3 дахин өссөнтэй холбоотой.

Зураг 1 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Салбарын нийт хөрөнгийн 91.1% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 272 ББСБ, 6.4% нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 104 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 2.5 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 137 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	2,679.3	109	76.0%	21.2%	8.7	1	5.9	1	5.3	1
2.5-5.0 тэрбум	532.5	163	15.1%	31.8%	6.7	2	5.3	2	-	-
1.9-2.5 тэрбум	225.7	104	6.4%	20.3%	-	-	4.2	2	2.0	1
1.4-1.9 тэрбум	35.4	22	1.0%	4.3%	6.2	4	6.3	4	-	-
0.6-1.4 тэрбум	27.0	28	0.8%	5.5%	6.7	8	9.4	10	4.4	5
0.6 тэрбум хүртэлх	27.2	87	0.8%	17.0%	0.5	1	15.8	57	10.9	29
НИЙТ	3,527.0	513	100.0%	100.0%	28.8	16	46.9	76	22.6	36

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын актив 1.8 их наяд төгрөг байгаа нь нийт активын 51.1 хувийг, нийт зээлийн үлдэгдэл 1.4 их наяд төгрөг байгаа нь нийт зээлийн үлдэгдлийн 52.8 хувийг бүрдүүлж байна.

Мөнгөн хөрөнгө


Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 60.8 тэрбум төгрөгөөр буюу 14.2 хувиар өсөж 490.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Бүтцээр нь авч үзвэл 21.9% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 44.6% нь банк, санхүүгийн байгууллагын харилцах дансанд 33.5% нь банк, санхүүгийн байгууллагын хадгаламжийн дансанд байршиж байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
МӨНГӨН ХӨРӨНГӨ	490.5	221.1	287.3	203.2	22.4	473.3	17.2	62.3	60.3
Бэлэн мөнгө	107.4	4.1	103.6	3.8	16.7	99.0	8.4	0.1	3.6
Харилцах	218.7	106.0	119.1	99.6	5.2	211.6	7.1	36.8	29.3
Хадгаламж	164.4	111.0	64.6	99.8	0.4	162.7	1.7	25.4	27.4

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 36.1%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 1.9%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч гадаад валютын арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 74.5% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Зураг 2 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 28.7% буюу 6.5 тэрбум төгрөгөөр буурч, 2022 оны жилийн эцсийн байдлаар 31 ББСБ 29.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна. Богино хугацаат хөрөнгө оруулалтын 38.2% буюу 11.1 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын үнэт цаас, 61.8% буюу 18.0 тэрбум төгрөгийг арилжааны үнэт цаас бүрдүүлж байна. Төрлөөр авч үзвэл 59.6% буюу 17.4 тэрбум төгрөг нь хувьцаа, 39.2% буюу 11.4 тэрбум төгрөг нь өрийн бичгээр, 1.1% буюу 333.9 сая төгрөг нь бусад үнэт цаасаарх хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
БХХО (ЦЭВРЭЭР)	29,082.5	24,120.7	5,247.4	23,835.0	1.0	28,307.2	775.3	16,681.7	12,785.0
Хувьцаа	17,394.4	15,842.6	4,737.4	12,656.9	1.0	16,619.1	775.3	11,234.2	8,342.0
Өрийн бичиг	11,445.9	8,045.9	500.0	10,945.9	-	11,445.9	-	5,123.6	4,443.0
Бусад	333.9	323.9	10.0	323.9	-	333.9	-	323.9	-
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	11,148.4	9,849.6	1,298.8	9,849.6	-	11,113.8	34.6	8,875.2	8,342.0
Арилжааны үнэт цаас	18,025.7	14,362.7	3,948.7	14,077.0	1.0	17,285.0	740.7	7,806.5	4,443.0

Тайлант улиралд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөлтэй 22 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 31 ББСБ санхүүгийн тайлангаар богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан ба эдгээрийн 14 ББСБ нь тусгай зөвшөөрөлтэй байна.

Засгийн газрын бондыг эрсдэлгүй гэж үзэн СЗХ-оос тухайн төрлийн бондыг тусгай зөвшөөрөлгүйгээр авах боломжтой гэж үзсэн хэдий ч санхүүгийн тайлангийн Засгийн газрын үнэт цаас хэсэгт бүртгэсэн дүн байхгүй байна.

Факторингийн тооцооны авлага

Факторингийн тооцооны авлага өмнөх оны мөн үеэс 5.1% буюу 526.1 сая төгрөгөөр буурч, 13 ББСБ 9.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. 2022 оны жилийн эцсийн байдлаар 5 ББСБ 522.1 сая төгрөгийн анхаарал хандуулах болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 140.8 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 9.7 тэрбум төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарчээ. Факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгдсэн хэдий ч факторингийн тусгай зөвшөөрөлтэй 45 ББСБ-уудын 32 ББСБ нь тусгай зөвшөөрөл олгосноос хойш үйл ажиллагаа эрхлэхгүй байгаа нь тул журамд заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шаардлагатай гэж үзэж байна.

Хүснэгт 14 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/

Нийт факторингийн тооцооны авлага	2021		2022		Өөрчлөлт	
	Нийт дүн 10,386.1	Эзлэх хувь 100.0%	Нийт дүн 9,860.0	Эзлэх хувь 100.0%	Дүн	Хувь
Хэвийн	9,479.2	91.3%	9,337.9	94.7%	(141.3)	-1.5%
Анхаарал хандуулах	193.7	1.9%	206.5	2.1%	12.8	6.6%
Чанаргүй	713.2	6.9%	315.6	3.2%	(397.6)	-55.7%
Хэвийн бус	109.0	1.0%	132.3	1.3%	23.3	21.4%
Эргэлзээтэй	248.2	2.4%	171.9	1.7%	(76.3)	-30.7%
Муу	356.0	3.4%	11.4	0.1%	(344.6)	-96.8%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	517.0	5.0%	140.8	1.4%	(376.3)	-72.8%

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 10.5 тэрбум төгрөг буюу 77.4 хувиар өсөж 24.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 15 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ӨБҮХХ БОЛОН ӨБХ (ЦЭВРЭЭР)	24,161.4	13,525.7	16,803.7	7,357.7	24,161.4	-	2,392.3	21,769.1	3,490.1
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	29,798.3	17,460.8	19,677.9	10,120.5	29,798.3	-	3,653.0	26,145.4	4,515.8
(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдэлийн сан)	7,679.9	4,308.1	4,693.0	2,986.9	7,679.9	-	1,260.7	6,419.2	1,627.1
Өмчлөх бусад хөрөнгө	2,043.0	373.1	1,818.9	224.1	2,043.0	-	-	2,043.0	601.4

Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 35.3% буюу 710.5 тэрбум төгрөгөөр өсөж 2022 оны жилийн эцсийн байдлаар 2,722.6 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 151.4 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 2,571.3 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 16 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/


	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	2,571.3	1,527.6	1,371.1	1,200.2	2,521.2	50.0	407.5	2,163.8	394.0
Нийт зээл	2,722.6	1,602.6	1,465.0	1,257.6	2,667.1	55.6	420.7	2,302.0	410.5
Хэвийн	2,409.1	1,444.9	1,277.6	1,131.5	2,360.8	48.3	389.5	2,019.6	375.6
Анхаарал хандуулах	106.5	58.6	61.1	45.4	105.3	1.2	11.9	94.6	11.9
Чанаргүй:	207.0	99.1	126.3	80.7	201.0	6.0	19.3	187.8	23.1
-Хэвийн бус	55.9	26.9	29.8	26.1	55.4	0.5	7.7	48.2	6.2
-Эргэлзээтэй	53.5	26.3	27.2	26.4	52.9	0.6	5.8	47.7	5.7
-Муу	97.6	45.9	69.4	28.2	92.7	4.9	5.7	91.9	11.2
(Зээлийн эрсдэлийн сан)	151.4	74.9	94.0	57.4	145.8	5.5	13.2	138.2	16.5
Нийт зээл (төгрөгийн)	2,644.0	1,540.7	1,448.1	1,195.8	2,588.9	55.1	390.5	2,253.4	376.6
Нийт зээл (валютын)	78.7	61.9	16.9	61.8	78.2	0.5	30.1	48.5	33.9
Зээлдэгчдийн тоо	1,187,603	689,182	207,166	980,437	1,161,737	25,866	207,110	980,493	132,503
- Иргэн	1,187,603	689,182	207,166	980,437	1,161,737	25,866	207,110	132,503	1,102,983
- Хуулийн этгээд	1,611	569	1,146	465	1,559	52	208	284	878

/Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно/

Тайлант улиралд ББСБ-ууд 4.7 их наяд төгрөгийн зээлийг 3.1 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 3.9 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2022 оны жилийн эцсийн байдлаар 1,187,603 зээлдэгчийн 2.7 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 88.5 хувийг буюу 2.4 их наяд төгрөгийг хэвийн зээл, 3.9 хувийг буюу 106.5 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 7.6 хувийг буюу 207.0 тэрбум төгрөг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.


Зураг 3 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.1 пунктээр буурсан бол анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан 1.4, 0.6 пунктээр өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 313.5 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 48.3%-д буюу 151.4 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар нийт зээлд эзлэх анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ 11.5% байна.

Зураг 4 Зээлийн багцын чанар /хувиар/



Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-аар нийт олгосон зээлийн 77.1% буюу 3.6 их наяд төгрөг нь бусад ангилалд /ихэвчлэн хэрэглээний зээл/, 8.3% буюу 388.5 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 77.8% буюу

3.1 их наяд төгрөг нь бусад ангиллын зээлээс, 8.2% буюу 324.0 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.


Олгосон зээлийн 91.4% буюу 4.3 их наяд төгрөгийн зээлийг иргэдэд, 8.6% буюу 404.8 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 91.5% буюу 3.6 их наяд төгрөг нь иргэдээс, 8.5% нь буюу 335.6 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.

Хүснэгт 17 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/

№	Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	36,036.2	0.8%	24,769.0	0.6%	35,419.2	1.3%
2.	Уул уурхай, олборлолт	37,276.3	0.8%	41,736.5	1.1%	49,480.3	1.8%
3.	Боловсруулах үйлдвэрлэл	31,417.4	0.7%	24,584.9	0.6%	35,421.7	1.3%
4.	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	5,294.6	0.1%	3,437.2	0.1%	4,785.1	0.2%
5.	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	2,058.7	0.0%	2,493.1	0.1%	1,738.5	0.1%
6.	Барилга	190,305.4	4.1%	162,128.1	4.1%	209,306.8	7.7%
7.	Бөөний болон жижиглэн худалдаа	388,545.6	8.3%	323,985.1	8.2%	328,669.9	12.1%
8.	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	76,839.3	1.6%	50,153.5	1.3%	93,989.1	3.5%
9.	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	45,612.0	1.0%	31,460.2	0.8%	38,462.6	1.4%
10.	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	61,820.7	1.3%	47,945.2	1.2%	92,898.0	3.4%
11.	Мэдээлэл холбоо	8,204.6	0.2%	6,404.7	0.2%	8,457.3	0.3%
12.	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	109,758.5	2.3%	96,228.8	2.4%	49,862.5	1.8%
13.	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	16,000.6	0.3%	11,498.2	0.3%	18,957.4	0.7%
14.	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2,648.0	0.1%	3,284.3	0.1%	4,659.5	0.2%
15.	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	24,385.6	0.5%	20,078.0	0.5%	20,967.2	0.8%
16.	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1,832.5	0.0%	1,578.6	0.0%	1,515.6	0.1%
17.	Боловсрол	16,642.3	0.4%	11,656.7	0.3%	14,756.4	0.5%
18.	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	17,614.8	0.4%	14,035.4	0.4%	14,034.2	0.5%
19.	Бусад	3,611,179.4	77.1%	3,069,645.1	77.8%	1,699,250.1	62.4%
<i>Иргэнд олгосон зээл</i>		4,278,653.3	91.4%	3,611,524.7	91.5%	2,400,057.8	88.2%
<i>Хуулийн этгээдэд олгосон зээл</i>		404,819.3	8.6%	335,578.1	8.5%	322,573.4	11.8%
НИЙТ		4,683,472.6	100.0%	3,947,102.7	100.0%	2,722,631.2	100.0%

Тайлант улиралд олгосон 4.7 их наяд төгрөгийн зээлийг хугацааны ангиллаар харвал 1-2.5 жилийн хугацаатай олгосон зээл нийт зээлийн 21.9 хувийг, 6-12 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 18.3 хувийг буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлж байна.

Зураг 5 Олгосон зээл /хугацааны ангиллаар/



Нийт зээлийн үлдэгдлийн ангиллаас харахад 4.7 их наядын зээлийн 53.9 хувийг иргэнд олгосон хэрэглээний зээл, 20.7 хувийг автомашинд зориулсан зээл, 9.6 хувийг хуулийн этгээдэд олгосон бизнесийн зээл бүрдүүлж байна.

Хүснэгт 18 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/

Зээлийн ангиллаар	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
Иргэнд олгосон зээл	4,278.7	91.4%	3,611.5	91.5%	2,400.1	88.2%
Хэрэглээнд зориулсан зээл	3,215.7	68.7%	2,823.6	71.5%	1,468.1	53.9%
<i>Үүнээс: Автомашинд зориулсан зээл</i>	<i>699.4</i>	<i>14.9%</i>	<i>545.0</i>	<i>13.8%</i>	<i>564.3</i>	<i>20.7%</i>
Бизнес зориулсан зээл	618.3	13.2%	410.9	10.4%	589.9	21.7%
Үл хөдлөх эд хөрөнгөд зориулсан зээл	104.0	2.2%	93.9	2.4%	151.5	5.6%
Бусад зээл	340.6	7.3%	283.1	7.2%	190.5	7.0%
Хуулийн этгээдэд олгосон зээл	404.8	8.6%	335.6	8.5%	322.6	11.8%
Бизнесийн зээл	335.3	7.2%	277.8	7.0%	261.7	9.6%
Автомашинны зээл	5.7	0.1%	6.7	0.2%	5.4	0.2%
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл	14.0	0.3%	9.4	0.2%	13.4	0.5%
Бусад зээл	49.8	1.1%	41.7	1.1%	42.1	1.5%
НИЙТ	4,683.5	100.0%	3,947.1	100.0%	2,722.6	100.0%

Цахим зээл

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2022 оны жилийн эцсийн байдлаар 37 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 19 Зээлийн ангилал

	Зээлийн дүн	Нийт дүнд эзлэх хувь	Зээлдэгчдийн тоо	Нийт дүнд эзлэх хувь	Дундаж зээл
Уламжлалт	2,261,616,017.0	83.1%	251,628	21.2%	8,987.9
Цахим зээл	461,015,165.0	16.9%	935,975	78.8%	492.6
Нийт	2,722,631,182.0	100.0%	1,187,603	100.0%	2,292.5

2022 оны жилийн эцсийн байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 935,975 зээлдэгчийн 461.0 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 78.8 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 16.9 хувийг бүрдүүлж байна. Нэг зээлдэгчид дунджаар 492.6 мянган төгрөгийн зээл олгосон байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 18.2 дахин бага байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 160 дугаар тогтоолоор “[Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам](#)”-ыг баталсан. Уг журам нь Хууль зүйн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 5807 дугаарт бүртгэгдэж, [Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлийн 2022 оны 13 дугаарт](#) нийтлэгдсэнээр финтек зээл олгож байгаа ББСБ-уудын эрх зүйн орчин бүрдсэн.

Энэхүү журам батлагдахаас өмнө финтек зээлийн үйлчилгээ эрхэлж байсан ББСБ-ууд дээрх тогтоолын 3-т заасны дагуу 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор журамд заасан шаардлагыг ханган Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхийг үүрэг болгосон.

Ногоон зээл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 2022 оны 03 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулсан “НОГООН САНХҮҮЖИЛТ - БҮС НУТГИЙН ЧУУЛГАН” өндөр түвшний форумын үеэр Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүд болох, Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Хадгаламжийн Даатгалын Корпорацийн төлөөллүүд Тогтвортой санхүүгийн үндэсний замын зургийг баталлаа.

Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг нь Монгол Улсын тогтвортой хөгжил, уур амьсгалын зорилтуудтай уялдсан нэгдмэл олон талт хамтын ажиллагааг хангасан, тогтвортой санхүүгийн системийг 2030 он хүртэл хөгжүүлэх, ингэснээр бүс нутагтаа тогтвортой санхүүгийн мэдлэг, манлайллын төв болох зорилго тавьсан. Үүний хүрээнд 2030 он гэхэд банкны салбарын ногоон зээлийн багцыг нийт зээлийн багцын 10 хувьд, банкнаас бусад санхүүгийн байгууллагын олгосон нийт зээлийн багцын таваас доошгүй хувийг ногоон зээлээр бүрдүүлэх зорилт дэвшүүлсэн.

Үүний дагуу 2022 оны II улирлаас эхлэн “Монгол Улсын Ногоон таксономи”-ийн үндсэн 8 ангиллын дагуу ББСБ-уудаас “Ногоон зээлийн тайлан”-г авч эхлээд байна.

- ❖ **Ногоон таксономи** гэдэг нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны ангилал, тодорхойлолт, шалгуур үзүүлэлт бөгөөд банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон бодлого боловсруулагчид энэхүү таксономийг ногоон зээл, ногоон хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлохдоо ашиглана. Ногоон таксономи нь аль нэг салбараар хязгаарлагдахгүй, бизнесийн бүхий л салбарыг хамаарах шалгуур үзүүлэлт юм.

Тайлант хугацаанд 22 ББСБ 5,481 зээлдэгчид 97.1 тэрбум төгрөгийн зээлийг дунджаар 2.0 хувийн хүүтэйгээр олгож, 23 ББСБ-ын 10,798 зээлдэгчээс 56.4 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2022 оны жилийн эцсийн байдлаар 25 ББСБ 9,101 зээлдэгчийн 117.4 тэрбум төгрөгийн “**ногоон**” зээлийн үлдэгдэлтэй гарчээ. Энэ нь салбарын нийт зээлийн үлдэгдлийн 4.3%-тай тэнцэж байна.


Хүснэгт 20 Ногоон зээлийн тайлан /сая төгрөгөөр/

НОГООН ТАКСОНОМИ ҮНДСЭН 8 АНГИЛАЛ	Олгосон зээлийн		Төлөгдсөн зээлийн		Зээлийн эцсийн үлдэгдлийн	
	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо
1. СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ	-	-	-	-	-	-
2. БАГА БОХИРДУУЛАГЧ ЭРЧИМ ХҮЧ	16.5	1	140.5	2	125.0	1
3. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ	521.0	54	44.0	57	876.6	57
4. НОГООН БАРИЛГА	1,169.2	111	1,485.7	179	6,305.6	789
5. БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	206.7	2	156.8	2	206.6	1
6. ТОГТВОРТОЙ УС, ХАЯГДЛЫН ХЭРЭГЛЭЭ	-	-	-	-	-	-
7. ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР АШИГЛАЛТ, ОЙ БОЛОН ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ	2,530.8	21	646.8	22	2,574.6	20
8. КАРБОН БАГА ЯЛГАРУУЛДАГ ТЭЭВЭР	92,691.5	5,292	53,935.8	10,536	107,328.9	8,233
Үүнээс:						
0-5 хүртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр	69.2	4	31.1	5	161.0	14
5-10 хүртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр	81,666.3	4,262	48,793.3	8,692	82,032.5	5,762
10-аас дээш жилийн ашиглалтын жилтэй тээвэр	10,956.0	1,026	5,111.5	1,839	25,135.4	2,457
НИЙТ	97,135.7	5,481	56,409.6	10,798	117,417.3	9,101

Ногоон зээлийн үлдэгдлийн 91.4% буюу 107.3 тэрбум төгрөгийг карбон бага ялгаруулдаг тээврийн хэрэгслийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Сэргээгдэх эрчим хүч, тогтвортой ус, хаягдлын хэрэглээний салбаруудад зээлийн үлдэгдэл байхгүй байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 97.3% нь хэвийн, 1.1% нь анхаарал хандуулах, 1.6% нь чанаргүй ангилалд ангилагдсан ба Ногоон барилгын салбарын зээлийн үлдэгдэл хамгийн их буюу 2.6% нь чанаргүй ангилалд ангилагдсан байна.

Зураг 6 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 8 ангиллаар/



Бусад хөрөнгө

2022 оны жилийн эцсийн байдлаарх 291.0 тэрбум төгрөгийн бусад хөрөнгийн үлдэгдлийн 44.4% буюу 129.1 тэрбум төгрөг нь хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, 31.7% буюу 92.3 тэрбум төгрөг нь дансны цэвэр авлага, 23.9% буюу 69.6 тэрбум төгрөг нь бусад актив байна.

Хүснэгт 21 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
БУСАД ХӨРӨНГӨ	290,968.7	151,565.3	214,935.0	76,033.7	12.8	285,615.2	5,353.5	24,473.2	266,495.5
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	129,119.3	61,798.5	89,980.3	39,139.0	-	127,389.7	1,729.6	10,402.6	118,716.7
-Үнэг цаасны	297.4	209.2	-	297.4	-	297.4	-	118.1	179.3
-Зээлийн	125,052.6	59,031.2	87,624.6	37,428.0	-	123,352.6	1,700.0	9,467.2	115,585.5
-Факторингийн	245.3	208.5	28.9	216.4	-	245.3	-	-	245.3
-Бусад	3,523.9	2,349.6	2,326.7	1,197.1	-	3,494.3	29.5	817.3	2,706.6
Авлага /цэврээр/	92,286.1	59,766.8	79,847.3	12,438.8	6.5	89,888.0	2,398.1	8,051.0	84,235.1
Нийт авлага	95,665.2	62,370.0	81,644.9	14,020.2	6.5	93,261.4	2,403.8	8,570.6	87,094.6

Хэвийн	89,402.4	59,320.8	77,159.0	12,243.4	3.0	87,012.2	2,390.3	8,030.7	81,371.7
Хугацаа хэтэрсэн	279.9	201.8	183.4	96.5	3.5	271.6	8.3	6.1	273.8
Чанаргүй:	5,982.8	2,847.4	4,302.5	1,680.4	-	5,977.6	5.2	533.8	5,449.0
-Хэвийн бус	149.9	132.9	14.7	135.2	-	149.9	-	12.3	137.5
-Эргэлзээтэй	2,422.7	34.1	2,387.9	34.8	-	2,422.7	-	10.6	2,412.0
-Муу	3,410.3	2,680.4	1,899.9	1,510.4	-	3,405.1	5.2	510.8	2,899.5
Нийт авлага (валютын)	62,870.7	30,075.4	49,921.9	12,948.8	6.5	60,466.9	2,403.8	7,939.0	54,931.7
Нийт авлага (төгрөгийн)	32,794.5	32,294.6	31,723.0	1,071.5	-	32,794.5	-	631.6	32,162.9
(Авлагын эрдэлийн сан)	3,379.0	2,603.1	1,797.6	1,581.4	-	3,373.4	5.7	519.5	2,859.5
Бусад актив	69,563.3	30,000.0	45,107.4	24,455.9	6.3	68,337.5	1,225.8	6,019.6	63,543.7

Эргэлтийн бус хөрөнгө

ББСБ-ууд 2022 оны жилийн эцсийн байдлаар 146.1 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 34.9 тэрбум төгрөгийн элэгдлийг хуримтлуулж бүртгэсэн байна. Ингэснээр тайлант хугацаанд 111.2 тэрбум төгрөгийн биет ба биет бус хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 22 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

ҮНДСЭН (БИЕТ) БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	146.1	70.5	84.1	62.0	0.3	142.4	3.7	13.8	14.9
Барилга байгууламж	47.6	30.5	22.9	24.7	0.1	46.4	1.2	2.4	2.0
Техник хэрэгсэл	53.8	18.2	40.4	13.4	0.1	52.1	1.7	3.0	4.6
Тавилга эд хогшил	17.5	8.9	10.1	7.4	0.2	17.1	0.4	3.3	3.9
Дуусаагүй барилга	6.8	2.4	4.6	2.2	0.0	6.8	0.0	0.1	0.3
Биет бус хөрөнгө	20.4	10.5	6.0	14.3	0.0	20.1	0.2	5.1	4.1
(Хуримтлагдсан элэгдэл)	34.9	17.0	22.0	12.9	0.1	33.8	1.1	4.6	4.7
Барилга байгууламжийн	7.2	4.8	2.9	4.2	0.0	7.0	0.2	1.3	0.1
Техник хэрэгслийн	19.9	7.8	14.6	5.3	0.0	19.1	0.7	1.4	2.3
Тавилга эд хогшлын	7.8	4.4	4.4	3.4	0.1	7.7	0.2	1.9	2.3

Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 30.1 хувиар буюу 817.0 тэрбум төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 52.0 хувийг өр төлбөрийн өсөлт, 48.0 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Пассивын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 23 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Пассивын үзүүлэлтүүд	2021	Нийт дүнд эзлэх хувь	2022	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
	дүн		дүн		дүн	хувь
Өр төлбөр	910,808.8	33.6%	1,335,379.9	37.9%	424,571.1	46.6%
Санхүүгийн эх үүсвэр	246,887.0	9.1%	381,147.1	10.8%	134,260.0	54.4%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	282,915.0	10.4%	396,763.2	11.2%	113,848.2	40.2%
Бусад эх үүсвэр	54,361.7	2.0%	48,136.3	1.4%	(6,225.4)	-11.5%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	149,772.8	5.5%	228,300.0	6.5%	78,527.3	52.4%
Төслийн зээлийн санхүүжилт	19,884.5	0.7%	29,990.8	0.9%	10,106.3	50.8%
Бусад өр төлбөр	156,987.9	5.8%	251,042.5	7.1%	94,054.6	59.9%
Эздийн өмч	1,799,140.8	66.4%	2,191,579.4	62.1%	392,438.6	21.8%
Хувьцаат капитал	1,114,075.1	41.1%	1,275,684.5	36.2%	161,609.4	14.5%
Бусад өмч	50,593.2	1.9%	62,333.2	1.8%	11,740.0	23.2%
Сангууд	973.3	0.0%	2,724.2	0.1%	1,751.0	179.9%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	563,339.2	20.8%	774,842.4	22.0%	211,503.2	37.5%
Хоёрдогч өглөг	70,160.0	2.6%	75,995.0	2.2%	5,835.0	8.3%
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	2,709,949.6	100.0%	3,526,959.3	100.0%	817,009.7	30.1%

Сүүлийн 5 жилийн пассивын үзүүлэлтийг харвал 2022 оны жилийн эцсийн байдлаар салбарын нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 2017 оны мөн үетэй харьцуулахад 2.9 дахин өсөж 2.2 их наяд төгрөгт, өр төлбөрийн хувьд 6.3 дахин өсөж 1.3 их наяд төгрөгт хүрсэн байна.


Зураг 7 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Санхүүгийн эх үүсвэр

2022 оны жилийн эцсийн байдлаар итгэлцлийн үйлчилгээний өглөг өмнөх оны мөн үеэс 54.4% буюу 134.3 тэрбум төгрөгөөр өсөж, итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 64 ББСБ-аас 58 ББСБ 7,365 итгэмжлэгчээс 381.1 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

Зураг 8 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/



Улаанбаатар хотын 58 ББСБ 7,359 итгэмжлэгчээс 380.4 тэрбум төгрөг, хөдөө орон нутгийн 1 ББСБ 6 итгэмжлэгчээс 0.8 тэрбум төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 24 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/

	Дүн	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	381.1	97.6	283.5	380.4	0.8	131.6	249.5	99.4
-Төгрөгөөр	312.4	93.3	219.2	311.7	0.8	96.3	216.2	99.4
-Валютаар	68.7	4.3	64.4	68.7	-	35.4	33.4	81.4
Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын тоо	64	45	19	63	1	5	59	6
-Үүнээс итгэлцлийн үйлчилгээний өглөгтэй ББСБ-уудын тоо	59	40	19	58	1	5	54	5
Нийт итгэмжлэгчдийн тоо	7,365	3,073	4,292	7,359	6	2,080	5,285	297

Хамгийн өндөр дүнгээр буюу 83.0 тэрбум төгрөгийг 193 итгэмжлэгчээс татан төвлөрүүлсэн бол хамгийн олон буюу 2,488 итгэмжлэгчээс 779.2 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг

2022 оны жилийн эцсийн байдлаар дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 40.2 хувиар өсөж, 95 ББСБ дотоод, гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас 396.8 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 25 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/

Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
396.8	396.8		307.4	181.0	215.8	394.2	2.5	78.4	318.4	85.6
Хугацаагаар:										
Богино хугацаат зээл	165.2	41.6%	135.4	100.0	65.3	164.5	0.7	19.1	146.2	24.0
Урт хугацаат зээл	231.5	58.4%	172.0	81.0	150.5	229.7	1.8	59.3	172.2	61.6
Валютын төрлөөр:										
Төгрөгөөр	305.4	77.0%	240.3	131.1	174.3	302.9	2.5	59.0	246.4	53.8
Валютаар	91.4	23.0%	67.1	49.9	41.4	91.4	-	19.4	72.0	31.8
Зээл авсан байгууллагаар:										
Дотоодын банк, санхүүгийн байгууллагаас	314.8	79.4%	249.0	131.8	183.0	312.3	2.5	67.5	247.4	58.1
Зээл /төгрөгөөр/	305.4	77.0%	240.3	131.1	174.3	302.9	2.5	59.0	246.4	53.8
Зээл /валютаар/	9.4	2.4%	8.7	0.7	8.7	9.4	-	8.5	1.0	4.3
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас	81.9	20.6%	58.4	49.2	32.7	81.9	-	10.9	71.0	27.5

Бусад эх үүсвэр

2022 оны жилийн эцсийн байдлаар 15 ББСБ 48.1 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарчээ. Үүнээс нэр бүхий 6 ББСБ 12.2 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийн үлдэгдэлтэй, нэр бүхий 2 ББСБ 142.7 сая төгрөгийн төлбөр тооцооны үйлчилгээний өглөгийн үлдэгдэлтэй, нэр бүхий 8 ББСБ 35.8 тэрбум төгрөгийн факторингийн үйлчилгээний өглөгтэй гарчээ.

Хүснэгт 26 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/

Бусад эх үүсвэр	Дүн	Эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХК
Нийт	48,136.3	100.0%	34,788.7	31,653.8	16,482.5	48,136.3	460.9
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	12,217.7	25.4%	9,367.9	1,728.5	10,489.2	12,217.7	460.9
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	142.7	0.3%	140.1	2.6	140.1	142.7	-
Факторингийн үйлчилгээний өглөг	35,775.9	74.3%	25,280.6	29,922.7	5,853.2	35,775.9	-

Өмнөх оны мөн үеэс мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг 17.5 хувиар, төлбөр тооцооны үйлчилгээний өглөг 54.9 хувиар, факторингийн үйлчилгээний өглөг 8.8 хувиар тус тус буурсан байна.

Зураг 9 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /мянган төгрөгөөр/

Бусад эх үүсвэр	2018.III	2019.III	2020.III	2021.III	2022.III
Зээлийн батлан даалтад байршуулсан эх үүсвэр	-	-	-	-	-
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	4,020,802.3	3,991,020.4	5,985,400.3	14,809,952.7	12,217,667.8
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	3,513,226.4	4,400,897.2	5,652,901.9	316,837.0	142,735.6
Факторингийн үйлчилгээний өглөг	8,134,245.2	24,873,518.3	31,512,175.2	39,234,782.4	35,775,861.1
Гадаад валютын арилжааны эх үүсвэр	-	-	-	112.5	-
Нийт	15,668,273.8	33,265,435.8	43,150,477.5	54,361,684.6	48,136,264.5

Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа болон гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудаас бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ байхгүй байна.

ББСБ-аас гаргасан өрийн бичиг


2022 оны жилийн эцсийн байдлаар 37 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд өрийн бичиг гаргаж, үүнийг 1,537 хувь хүн, хуулийн этгээд худалдан авсан ба нийт 228.3 тэрбум төгрөгийн өрийн бичгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 27 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/

ББСБ-ААС ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	228,300.0	163,533.1	33,139.3	195,160.7	227,792.8	507.2	61,040.0	167,260.1	43,864.8
Төгрөгөөр	216,870.0	152,191.2	33,051.3	183,818.8	216,362.8	507.2	61,040.0	155,830.1	43,864.8
Валютаар	11,430.0	11,341.9	88.1	11,341.9	11,430.0	-	-	11,430.0	-


Өрийн бичгийн үлдэгдэл 2018 оны мөн үеэс 9.7 дахин өсөж 228.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зураг 10 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Өмнөх оны мөн үед валютаар гаргасан өрийн бичгийн нийт өрийн бичгийн үлдэгдэлд эзлэх хувийн жин 6.9% байсан бол 2022 оны жилийн эцсийн 1.9 пунктээр буурч 5.0%-д хүрсэн байна.

Хүснэгт 28 Өрийн бичиг /валютаар/



Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэгдээгүй, 2022 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн тайланд өрийн бичгийн үлдэгдэлтэй байгаа ББСБ-уудын журмын үйлчлэх хугацаанд зөвшөөрөлгүй өрийн бичиг шинээр болон нэмж гаргасан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 165 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам”-ын үйлчлэх хугацаанд (Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацаанд буюу 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хэрэгжсэн):

- ББСБГ-аас 32 ББСБ 57 удаагийн тогтоол шийдвэрээр 213,279,700.0 төгрөгийн хаалттай өрийн бичиг гаргах зөвшөөрөл,
- ҮЦГ-аас олон нийтэд хувьцаагаа санал болгосон 3 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд 82.6 тэрбум төгрөгийн, 1 ББСБ нээлттэй хүрээнд 1.0 тэрбум төгрөгийн өрийн хэрэгсэл гаргах зөвшөөрөл,
- Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 995 дугаар тогтоолоор баталсан “[Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам](#)”-ын дагуу 17 ББСБ 139,413,910,000.0 төгрөгийн өрийн бичиг гаргасан байна.

“Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам”-ын үйлчлэх хугацаа дууссан тул 2023 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн ББСБ-ууд өрийн бичиг гаргахдаа “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллана.

Төслийн зээлийн санхүүжилт

Төсөл хөтөлбөрөөс 12 ББСБ 30.0 тэрбум төгрөгийг төслийн санхүүжилтээр эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 29 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/

ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	29,990.8		15,984.7	23,329.6	6,661.2	28,149.6	1,841.2	6,661.2	23,329.6	8,892.7
Хугацаагаар										
Богино хугацаат	10,208.4	34.0%	6,371.3	3,862.1	6,346.3	10,014.8	193.6	6,346.3	3,862.1	-
Урт хугацаат	19,782.4	66.0%	9,613.4	19,467.5	314.9	18,134.8	1,647.7	314.9	19,467.5	8,892.7
Төрлөөр										
Засгийн газрын	-	-	-	-	-	-	-	-	-	-
Гадаадын	13,464.2	44.9%	13,464.2	6,803.0	6,661.2	13,464.2	-	6,661.2	6,803.0	6,803.0
Дотоодын	5,239.2	17.5%	2,520.5	5,239.2	-	3,607.9	1,631.2	-	5,239.2	2,089.8
Бусад	11,287.5	37.6%	-	11,287.5	-	11,077.5	210.0	-	11,287.5	-
Валютын төрлөөр										
Төгрөгөөр	26,850.0	89.5%	12,843.9	20,188.8	6,661.2	25,008.8	1,841.2	6,661.2	20,188.8	5,751.9
Валютаар	3,140.8	10.5%	3,140.8	3,140.8	-	3,140.8	-	-	3,140.8	3,140.8

Бусад өр төлбөр

2022 оны жилийн эцсийн байдлаар 481 ББСБ 251.0 тэрбум төгрөгийн бусад өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Үүний 15.1% буюу 38.0 тэрбум төгрөг нь 75 ББСБ-ын хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг, 84.8% буюу 213.0 тэрбум төгрөг нь 481 ББСБ-ын бусад пассив, 0.003% буюу 8.0 сая төгрөг нь 1 ББСБ-ын санхүүгийн үүсмэл хэрэгсэл (дериватив)-ийн өглөгийн үлдэгдэл байна.

Хүснэгт 30 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/

БУСАД ӨР ТӨЛБӨР	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	251,042.5	155,939.0	121,566.7	129,475.8	314.2	248,900.6	2,141.9	55,610.6	195,431.9	46,006.6
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг										
Ангиллаар										
Зээлийн	17,568.7	8,032.6	6,727.2	10,841.5	147.7	17,567.3	1.4	2,483.3	15,085.4	1,846.5
Үнэт цаасны	3,658.8	3,617.2	24.8	3,634.1	-	3,658.8	-	1,354.5	2,304.4	874.1
Бусад	16,801.8	15,744.5	3,265.9	13,535.9	-	16,787.6	14.2	4,353.1	12,448.8	2,846.9
Валютын төрлөөр										
Төгрөгөөр	34,910.4	24,546.4	9,299.6	25,610.8	147.7	34,894.8	15.6	7,309.8	27,600.6	4,796.7
Валютаар	3,118.9	2,848.0	718.3	2,400.7	-	3,118.9	-	881.0	2,237.9	770.8
Бусад пассив	213,005.1	128,536.6	111,548.9	101,456.2	166.5	210,878.8	2,126.3	47,419.8	165,585.3	40,439.1
Деривативийн өглөг	8.0	8.0	-	8.0	-	8.0	-	-	8.0	-

Хувь нийлүүлсэн хөрөнгө

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 14.5% буюу 161.6 тэрбум төгрөгөөр өсөж 1.3 их наяд төгрөгт хүрсэн ба энэ нь нийт пассивын 36.2 хувийг бүрдүүлж байна.


Хүснэгт 31 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/

Хувьцаат капитал	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	1,275,684.5	390,636.8	992,480.7	283,203.9	17,445.4	1,223,824.5	51,860.0	40,299.9	1,235,384.6	105,736.5
Энгийн хувьцаа	1,277,839.3	393,154.8	992,297.8	285,541.5	17,445.4	1,226,021.5	51,817.7	42,641.1	1,235,198.1	105,619.1
Давуу эрхтэй хувьцаа	393.3	30.0	393.3	-	-	351.0	42.3	-	393.3	121.0
Халаасны хувьцаа	2,548.0	2,548.0	210.4	2,337.6	-	2,548.0	-	2,341.2	206.8	3.6

Хувьцаат капиталын хэмжээ 2018 оны мөн үеэс 1.7 дахин өсөж 1.3 их наяд төгрөгт, үүнээс энгийн хувьцаа 1.7 дахин өсөж 1.3 их наяд төгрөгт, давуу эрхийн хувьцаа 1.6 дахин буурч 393.3 сая төгрөгт, халаасны хувьцаа 12.3 дахин өсөж 2.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар 516 ББСБ-ын 1.3 их наяд төгрөгийн энгийн хувьцаа, 4 ББСБ-ын 393.3 сая төгрөгийн давуу эрхийн хувьцаа, 4 ББСБ-ын 2.5 тэрбум төгрөгийн халаасны хувьцаа бүртгэгдсэн байна.

Зураг 11 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



1.9 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 377 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 94.7% буюу 1.2 их наяд төгрөг байна. Харин 1.9 тэрбум төгрөг хүртэлх хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 136 ББСБ-ын 67.6 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 5.3 хувийг бүрдүүлж байна.

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 254.9 тэрбум төгрөг байгаа нь нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 20.0 хувийг, бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн дүн 1.0 их наяд төгрөг байгаа нийт дүнгийн 76.5 хувийг бүрдүүлж байгаа зэргээс харахад томоохон ББСБ-ууд бусдаас хөрөнгө татан төвлөрүүлж үйл ажиллагаагаа явуулж байгаа тул хяналт шалгалтыг сайжруулах нь зүйтэй.

Хүснэгт 32 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	ХНХ	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	380.1	31	29.8%	6.0%	7.3	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	479.7	168	37.6%	32.7%	2.5	1	6.2	2	3.0	1
1.9-2.5 тэрбум	348.2	178	27.3%	34.7%	-	-	1.9	1	-	-
1.4-1.9 тэрбум	26.8	19	2.1%	3.7%	2.8	2	4.2	3	1.4	1
0.6-1.4 тэрбум	15.9	20	1.2%	3.9%	6.4	9	5.7	7	2.9	3
0.6 тэрбум хүргэлх	24.9	97	2.0%	18.9%	1.4	3	13.3	63	10.2	31
НИЙТ	1,275.7	513	100.0%	100.0%	20.4	16	31.3	76	17.4	36

Бусад өмч, сангууд

Бусад өмч өмнөх оны мөн үеэс 23.2 хувиар өсөж 62.3 тэрбум төгрөгт, сангууд 2.8 дахин өсөж 2.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 33 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/


	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Бусад өмч	62,333.2	56,027.7	15,731.2	46,602.0	81.6	61,978.3	354.9	53,938.8	8,394.4	39,510.3
Нэмж төлөгдсөн капитал	56,889.8	53,689.2	12,663.4	44,226.5	51.8	56,705.8	184.0	52,994.3	3,895.5	39,505.4
Дахин үнэлгээний нэмэгдэл	3,335.8	1,597.1	1,730.9	1,604.9	-	3,299.1	36.7	887.2	2,448.6	4.9
Хандивын капитал	2,107.5	741.3	1,336.9	770.6	29.7	1,973.3	134.2	57.3	2,050.2	-
Сангууд	2,724.2	1,712.2	2,708.8	15.4	-	1,966.8	757.4	14.7	2,709.5	15.9
Нөөцийн сан	2,219.4	1,682.9	2,219.4	-	-	1,689.3	530.1	-	2,219.4	14.9
Нийгмийн хөгжлийн сан	504.8	29.3	489.4	15.4	-	277.6	227.3	14.7	490.1	1.0

Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 37.5% буюу 211.5 тэрбум төгрөгөөр өсөж 774.8 тэрбум төгрөгт хүрчээ.

Тайлант хугацаанд 458 ББСБ 318.7 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол 6 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 49 ББСБ 5.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 34 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/




Хоёрдогч өглөг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хоёрдогч өглөгийн хэмжээ 8.3 хувиар өсөж 76.0 тэрбум төгрөгт хүрчээ. Тайлант хугацаанд 3 ББСБ 6,450.0 сая төгрөгийн хоёрдогч өглөг нэмж гаргах зөвшөөрөл авсан ба 2022 оны жилийн эцсийн байдлаар 8 ББСБ 76.0 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгийн үлдэгдэлтэй байна.

Ашигт ажиллагаа

2022 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-ууд 867.9 тэрбум төгрөгийн орлого олж, 554.9 тэрбум төгрөгийн зардал гаргаж 312.9 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зураг 12 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 66.5% буюу 346.6 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 78.3% буюу 243.7 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 49.0% буюу 102.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 35 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/

ОРЛОГО	2021	2022	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Хүүгийн орлого	421,707,391.2	701,959,166.1	80.9%	280,251,774.9	66.5%
Хүүгийн бус орлого	87,036,660.6	149,892,765.1	17.3%	62,856,104.5	72.2%
- Санхүүгийн үйлчилгээний орлого	72,973,722.9	82,950,313.7	9.6%	9,976,590.7	13.7%
- Итгэлцлийн үйлчилгээний орлого	15,634.4	64,518.0	0.0%	48,883.6	312.7%
- Мөнгөн гуйвуулгын орлого	2,616,496.7	2,747,549.5	0.3%	131,052.8	5.0%
- Картын үйлчилгээний орлого	4,330.2	327.8	0.0%	-4,002.4	-92.4%
- Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	149,555.2	477,220.9	0.1%	327,665.7	219.1%
- Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	47,280,655.5	67,576,176.8	7.8%	20,295,521.3	42.9%
- Бусад	22,907,050.9	12,084,520.7	1.4%	-10,822,530.2	-47.2%
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	12,452,378.7	15,821,216.4	1.8%	3,368,837.8	27.1%
Ердийн бус орлого	68,203.8	183,109.3	0.0%	114,905.5	168.5%
НИЙТ ОРЛОГО	521,264,634.2	867,856,256.8	100.0%	346,591,622.6	66.5%
ЗАРДАЛ					
Хүүгийн зардал	47,993,564.7	95,642,360.0	17.2%	47,648,795.3	99.3%
Хүүгийн бус зардал	193,491,809.2	335,215,597.3	60.4%	141,723,788.0	73.2%
Болзошгүй эрдэлийн зардал	37,303,481.2	69,068,740.7	12.4%	31,765,259.5	85.2%
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	6,712,666.0	8,216,476.5	1.5%	1,503,810.5	22.4%
Орлогын албан татварын зардал	25,711,307.0	46,764,319.4	8.4%	21,053,012.4	81.9%
Ердийн бус зардал	46,669.7	34,262.9	-	-12,406.7	-26.6%
НИЙТ ЗАРЛАГА	311,259,497.8	554,941,756.8	100.0%	243,682,259.0	78.3%
АШИГ					
ЦЭВЭР АШИГ	210,005,136.4	312,914,500.1	100.0%	102,909,363.6	49.0%

Өмнөх оны мөн үеэс хамгийн их өөрчлөлт орсон үзүүлэлтийг харвал орлогын хувьд итгэлцлийн үйлчилгээний орлого 4.1 дахин буюу 48.9 тэрбум төгрөгөөр өсжээ. Цар тахалтай холбоотойгоор сүүлийн 2 жилийн хугацаанд ББСБ-уудын ашигт ажиллагаанд төдийлөн өсөлт байхгүй байсан бол 2022 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-уудын үндсэн үйл ажиллагаа болох зээл олголт нэмэгдэж, үүнийгээ дагаад хүүгийн орлого болон үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого харгалзан 66.5 хувь болон 42.9 хувиар тус тус нэмэгдсэн байна. /Үйлчилгээний хураамж шимтгэлийн орлогын дийлэнх хувийг бага дүнтэй, богино хугацаатай, хүүгүй онлайн зээл олгож буй ББСБ-уудын үйлчилгээний шимтгэлийн дүн бүрдүүлж байна/.

ББСБ-ын ердийн үйл ажиллагаанаас илт ялгаатай үйл явдал, ажил гүйлгээнээс үүсдэг байнга давтагдан гарахгүй орлого ба зардлыг ердийн бус орлого, зарлага гэдэг. Тухайлбал байгалийн гамшиг болон гэнэтийн ослоос үүссэн давагдашгүй хүчин зүйлийн гарз хохирол, бэрхшээлтэй өрийн шинэчлэл зэрэг болно.

Ердийн бус орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.7 дахин өсөж 183.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тайлант хугацаанд энэ ердийн бус орлого дансанд үлдэгдэлтэй гарсан 11 ББСБ, ердийн бус зарлага дансанд үлдэгдэлтэй гарсан 9 ББСБ-ын тайланг тодруулах шаардлагатай.

Хүснэгт 36 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/

ОРЛОГО	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хүүгийн орлого	701,959.2	417,347.6	338,273.4	363,685.8	25.5	689,169.3	12,789.8	86,155.9	94,528.8
Хүүгийн бус орлого	149,892.8	106,039.9	61,142.6	88,750.2	3,186.1	148,438.9	1,453.8	40,946.7	18,067.7
- Санхүүгийн үйлчилгээний орлого	82,950.3	64,530.5	22,741.6	60,208.7	-	81,653.9	1,296.5	37,806.4	14,825.9
<i>Итгэлцлийн үйлчилгээний орлого</i>	64.5	64.5	-	64.5	-	64.5	-	-	-
<i>Мөнгөн гуйвуулгын орлого</i>	2,747.5	396.3	2,351.3	396.3	-	2,747.5	-	396.3	-
<i>Картын үйлчилгээний орлого</i>	0.3	-	0.3	-	-	0.3	-	-	-
<i>Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого</i>	477.2	477.2	432.7	44.5	-	477.2	-	44.5	-
<i>Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого</i>	67,576.2	59,313.5	10,077.1	57,499.1	-	66,517.5	1,058.7	36,898.5	14,081.2
<i>Бусад</i>	12,084.5	4,279.1	9,880.2	2,204.3	-	11,846.8	237.8	467.1	744.7
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	15,821.2	7,701.1	12,827.0	2,994.3	-	15,185.2	636.0	1,411.1	1,856.6
Ердийн бус орлого	183.1	0.0	160.8	22.3	-	168.9	14.2	-	-
НИЙТ ОРЛОГО	867,856.3	531,088.6	412,403.8	455,452.5	3,211.6	852,962.4	14,893.8	128,513.7	114,453.1
ЗАРДАЛ									
Хүүгийн зардал	95,642.4	67,330.5	31,615.2	64,027.2	-	95,022.4	620.0	17,014.8	12,973.8
Хүүгийн бус зардал	335,215.6	216,868.0	145,257.5	189,958.1	1,317.7	330,042.4	5,173.2	54,719.5	48,112.2
Болзошгүй эрсдэлийн зардал	69,068.7	39,747.3	27,918.1	41,150.6	-	68,197.7	871.1	9,788.4	7,953.8
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	8,216.5	3,424.1	4,780.4	3,436.1	0.2	8,047.4	169.1	907.4	924.5
Орлогын албан татварын зардал	46,764.3	31,408.0	21,024.2	25,740.1	72.7	46,207.5	556.8	9,180.6	8,854.7
Ердийн бус зардал	34.3	13.6	29.9	4.4	-	34.2	0.0	-	-
НИЙТ ЗАРЛАГА	554,941.8	358,791.5	230,625.3	324,316.4	1,390.6	547,551.5	7,390.2	91,610.5	78,819.1
АШИГ									
ЦЭВЭР ОРЛОГО	312,914.5	172,297.2	181,778.4	131,136.1	1,821.0	305,410.9	7,503.6	36,903.1	35,633.9

Зардлын хувьд өмнөх оны мөн үеэс хамгийн их өсөлт үзүүлсэн нь хүүгийн зардал болон ердийн бус зардал байна. Хүүгийн зардал болон хүүгийн бус зардал харгалзан 2.0 болон 1.7 дахин өсжээ. Хүүгийн зардлын өсөлтийн 61.2 хувийг банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал, 45.4 хувийг өрийн бичгийн хүүгийн зардлын өсөлт бүрдүүлж байна.


Эндээс харахад ББСБ-уудын эх үүсвэрийн зардал нэмэгдэж үүнийгээ дагаад үндсэн бүтээгдэхүүн болох зээлийн бүтээгдэхүүний үнэ өсөж байна.

Гадаад валютын арилжааны мэдээ

Тайлант хугацаанд гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 140 ББСБ-аас 72.8% буюу 108 ББСБ-аас ирүүлсэн тайлангаар 4,833.7 тэрбум төгрөгийн валют худалдан авсан нь банкны салбартай харьцуулахад 12.1 хувьтай тэнцэж байгаа бол 5,037.1 тэрбум төгрөгийн валют зарсан нь банкны салбартай харьцуулахад 13.2 хувьтай тэнцэж байна.


2022 оны 5, 6 сард доллар, юань, евро, иений арилжаа огцом нэмэгдсэн байна.

Хүснэгт 37 2022 оны жилийн эцсийн байдлаарх валют арилжааны мэдээ /тэрбум төгрөгөөр/



ББСБ-уудын ирцийн мэдээ сүүлийн 5 жилийн байдлаар дараах байдалтай байна.

Хүснэгт 38 Гадаад валютын арилжааны мэдээ /2022 он/



Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 513 ББСБ-ын 89.3% буюу 458 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 10.7% нь буюу 55 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 49 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 4 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 2 ББСБ байна.

Хүснэгт 39 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Итгэлцэл /64 ББСБ/		Итгэлцэл, ГВА-аас бусад /413 ББСБ/		ЗГВА /36 ББСБ/		Нийт /513 ББСБ/		
		√	X	√	X	√	X	√	X	
1.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	64	-	411	2	36	-	511	2	
2.	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	64	-	410	3	36	-	510	3	
3.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	64	-	411	2	36	-	511	2	
4.	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	63	1	409	4	36	-	508	5	
5.	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү,- дутуу)	61	3	394	19	35	1	490	23	
6.	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	64	-	404	9	XXX		504	9	
7.	ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	64	-	413	-			513	-	
8.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	64	-	413	-			513	-	
9.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	64	-	412	1			512	1	
10.	Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	64	-	413	-			513	-	
11.	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	64	-	413	-			513	-	
12.	Монголын хөрөнгийн биржийн “Г”, “П” ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа	64	-	413	-			513	-	
13.	Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	64	-	413	-			513	-	
14.	Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа	64	-	412	1			512	1	
15.	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	64	-	405	8			505	8	
16.	Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	64	-	XXX				513	-	
17.	Өрийн бичгийн зохистой харьцаа	64	-	413	-			513	-	
18.	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	63	1	401	12		36	-	500	13

Тайлбар: √ - ЗХШҮ хангасан ББСБ-ын тоо
X - ЗХШҮ хангаагүй ББСБ-ын тоо

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу 23 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 13 ББСБ, нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа алдагдсан 9 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 8 ББСБ буюу хамгийн их алдагдсан байна.

Бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлсэн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа алдагдсан 5 ББСБ-ын хяналтыг сайжруулж, анхаарч ажиллах шаардлагатай.

Дүгнэлт

2022 оны жилийн эцсийн байдлаар тайлан мэдээг ирүүлбэл зохих 513 ББСБ-аас 507 ББСБ тайлан мэдээг зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 5 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 1 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа. 2022 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 26,993 хувьцаа эзэмшигчдийн 513 ББСБ, 427 салбар нэгж, 8 төлөөлөгчийн газар, 4,554 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 4.6 сая харилцагч, 1.2 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

ББСБ-уудын нэгтгэлийн танилцуулгыг боловсруулах явцад бусдаас итгэлцэл болон өрийн бичиг хэлбэрээр эх үүсвэр татсан ББСБ-уудын тухайн үйлчилгээний харилцагчдын тоо нь статистик мэдээлэл болон тухайн тайлангийн дэлгэрэнгүй хэсэгт бөглөсөн тоо мэдээнээс зөрөх, аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд “Зээл олголт эргэн төлөлт, зээлийн хүүгийн судалгааны тайлан”-г дутуу нөхсөнөөс үүдэн мэдээллийг дахин тодруулах шаардлага үүсэж байна. Мөн шинээр авч байгаа тоо мэдээг нөхсөн байдал тун хангалтгүй байсан тул тухайн тайлангуудын нэгтгэлийг танилцуулгад дурдаагүй болно.

Актив, пассивын бүтэц

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 30.1 хувиар өсөж, банкны салбарын 7.7%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 78.8%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.1 пунктээр буурсан дүн юм. Энэ нь ББСБ-уудын бусдаас татан төвлөрүүлж буй эх үүсвэрийн хэмжээ нэмэгдэж байгааг харуулж байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 30.1 хувиар буюу 817.0 тэрбум төгрөгөөр өсөж 3.5 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 87.0 хувийг цэвэр зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 52.0 хувийг өр төлбөрийн өсөлт, 48.0 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

ББСБ-ууд нь ихэвчлэн өөрийн хөрөнгөд тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэг онцлогтой байсан хэдий ч сүүлийн 2 жилийн хугацаанд бусдаас итгэлцэл, өрийн бичиг, дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөр хэлбэрээр эх үүсвэр татах нь нэмэгдэж байгаа тул тэдгээр /136 ББСБ/ ББСБ-уудын тайлан мэдээнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай гэж үзэж байна.

Тайлант улиралд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөлтэй 22 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 31 ББСБ санхүүгийн тайлангаар богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан ба эдгээрийн 14 ББСБ нь тусгай зөвшөөрөлтэй байна.

Засгийн газрын бондыг эрсдэлгүй гэж үзэн СЗХ-оос тухайн төрлийн бондыг тусгай зөвшөөрөлгүйгээр авах боломжтой гэж үзсэн хэдий ч санхүүгийн тайлангийн Засгийн газрын үнэт цаас хэсэгт бүртгэсэн дүн байхгүй байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 35.3% буюу 710.5 тэрбум төгрөгөөр өсөж 2022 оны жилийн эцсийн байдлаар 2,722.6 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 151.4 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 2,571.3 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна. Нийт зээлийн үлдэгдлийн 88.5 хувийг буюу 2.4 их наяд төгрөгийг хэвийн зээл, 3.9 хувийг буюу 106.5 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 7.6 хувийг буюу 207.0 тэрбум төгрөг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.1 пунктээр буурсан бол анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан 1.4, 0.6 пунктээр өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 313.5 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 48.3%-д буюу 151.4 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 30.1 хувиар буюу 817.0 тэрбум төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 52.0 хувийг өр төлбөрийн өсөлт, 48.0 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад итгэлцлийн үйлчилгээний өглөг 54.4 хувиар, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 40.2 хувиар, ББСБ-аас гаргасан өрийн бичгийн үлдэгдэл 52.4 хувиар өссөн байгаа нь ББСБ-уудын хувьд бусдаас өртөг бүхий эх үүсвэрийг татан төвлөрүүлж байгааг харуулж байна.

Ашигт ажиллагаа

2022 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-ууд 867.9 тэрбум төгрөгийн орлого олж, 554.9 тэрбум төгрөгийн зардал гаргаж 312.9 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 66.5% буюу 346.6 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 78.3% буюу 243.7 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 49.0% буюу 102.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Цар тахалтай холбоотойгоор сүүлийн 2 жилийн хугацаанд ББСБ-уудын ашигт ажиллагаанд төдийлөн өсөлт байхгүй байсан бол 2022 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-уудын үндсэн үйл ажиллагаа болох зээл олголт нэмэгдэж, үүнийгээ дагаад хүүгийн орлого болон үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого харгалзан 66.5% болон 42.9 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 513 ББСБ-ын 89.3% буюу 458 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна. Нийт ББСБ-уудын 10.7% нь буюу 55 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 49 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 4 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 2 ББСБ байна.

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу 23 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 13 ББСБ, нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа алдагдсан 9 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 8 ББСБ буюу хамгийн их алдагдсан байна.

Бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлсэн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа алдагдсан 5 ББСБ-ын хяналтыг сайжруулж, анхаарч ажиллах шаардлагатай

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР